



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**“Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний
хэрэгжилт, үр дүн, үр ашиг”**

**Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд
захиалагч, зохиогчийн хяналтын үр дүнг
сайжруулах шаардлагатай байна.**

Аудитын код: ДГА-2021/06-9-ШТА-ГА

Цахим хуудас:
www.dornogovi.audit.mn

Дорноговь аймаг
2021 оны 04 сар

Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 70522734

Аудитын менежер:

Утас: 70523020

Ахлах аудитор:

Аудитор:

Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn

У.Оюунтүлхүүр

Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Ч.Ариунаа

Цахим хаяг: ariunaa.ch@audit.gov.mn

Т.Мөнхтогтох

Цахим хаяг: munkhtogtokht@audit.gov.mn

Агуулга

Хүснэгтийн товъёог	4
Дүрслэлийн товъёог	4
Хавсралтын товъёог	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	5
Ерөнхий мэдээлэл	7
БҮЛЭГ А Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт орон нутгийн хөгжлийн хэрэгцээ шаардлагад үндэслэж хийгдсэн ч зарим сайдаас хуульд тусгагдаагүй ажлыг хэрэгжүүлсэн байна.	8
А.1 Сангийн яамнаас хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх, хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр удирдлагын систем www.publicinvestment.gov.mn веб хуудсыг ашиглалтад оруулснаар санхүүжүүлэх үйл явц ил тод, нээлттэй болсон байна.	8
А.2 Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийлгэх ажил Төсвийн тухай хууль батлагдсаны дараа хийгдсээр байна.	9
А.3 Төсөл, арга хэмжээг үр ашигтай төлөвлөх талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна.	11
БҮЛЭГ Б Захиалагч гэрээний хэрэгжилтийг хугацаанд нь бүрэн хангуулж ажиллаагүй, гэрээний хугацаа хэтрүүлсэн гүйцэтгэгчид хариуцлага тооцоогүй байна.	14
Б.1 Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулсан байна.	14
Б.2 Захиалагч гэрээний хэрэгжилтийг хугацаанд нь бүрэн хангуулж ажиллаагүй байна.	18
Б.3 Захиалагч, зохиогчийн хяналтаар өгсөн зөвлөмж, үүрэг даалгаврын биелэлтийг дүгнэх үйл явц хангалтгүй байна.	22
Б.4 Гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг бүрэн хангуулах үүднээс чанарын баталгааны 5 хүртэлх хувийг барьцаа төлбөрийн дансанд байршуулдаг болсон байна.	23
Аудитын дүгнэлт	27
Аудитын зөвлөмж	29
Хавсралт	31
Холбогдох байгууллагын санал	32
Холбогдох байгууллагын саналд өгөх тайлбар	35
Гүйцэтгэлийн аудитын тайлан баталгаажуулах тухай тушаал	36

Товчилсон үгийн тайлбар

МУ	Монгол улс
ААН	Аж ахуйн нэгж
АГГ	Аудитын гуравдугаар газар
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АЗДТГ	Аймгийн Засаг даргын Тамгын газар
БСШУСС	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд
БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан яам
БТСГ	Биеийн тамир, спортын газар
БХБС	Барилга, хот байгуулалтын сайд
ГА	Гүйцэтгэлийн аудит
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
ЗГ	Засгийн газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ИТХТ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНӨХХК	Орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
СХАА	Санхүүгийн хяналт, аудитын алба
СЯ	Сангийн яам
ТАБ	Төрийн аудитын байгууллага
ТАХ	Төсөл арга хэмжээ
ТББ	Тендерийн баримт бичиг
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үнэлгээ
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХБТХ	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
ХНХС	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХҮГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
ШС	Шадар сайд
ШТА	Шууд тайлагнах аудит
ЭХС	Эрчим хүчний сайд
ЭЭС	Эм эргэлтийн сан

Хүснэгтийн товъёог:

Утга	Тайлбар
Хүснэгт №1	Орон нутгийн саналд үндэслээгүй батлуулсан ТАХ
Хүснэгт №2	Ажлын зураг төсөл боловсруулсан огноо
Хүснэгт №3	ТАХ-ний санхүүжилт
Хүснэгт №4	Эрх шилжүүлсэн байдал
Хүснэгт №5	Орон нутгаас ажиллах хүч авахаар давуу эрх тооцуулсан ААН
Хүснэгт №6	Төсөвт өртгийн дүнгээс тооцсон хувь хэмжээ
Хүснэгт №7	Тендер шалгаруулалттай холбоотой 2020 онд гарсан гомдол
Хүснэгт №8	Тоног төхөөрөмжийн жагсаалт
Хүснэгт №9	Тоног төхөөрөмжийн жагсаалт
Хүснэгт №10	Тоног төхөөрөмжийн жагсаалт

Дүрслэлийн товъёог:

Утга	Тайлбар
График №1	Санхүүжих дүн
График №2	Хэрэгжүүлэх ТАХ-ний тоо, төрөл

Зургийн товъёог:

Утга	Тайлбар
Зураг №1, 2	Төрөх эмнэлгийн ашиглалтгүй хөрөнгүүд
Зураг №3, 4, 5	Кино театрын хөрөнгүүд
Зураг №6, 7, 8	Сайншанд 1-р сургуулийн ашиглалтгүй хөрөнгүүд
Зураг №9, 10	Сайншанд 2-р сургуулийн ашиглалтгүй хөрөнгүүд
Зураг №11, 12, 13	Сайншанд 5-р сургуулийн ашиглалтгүй хөрөнгүүд

Хавсралтын товъёог

Утга	Тайлбар
Хавсралт №1	Орон нутгаас санал хүргүүлээгүй батлагдсан ТАХ-ний жагсаалт

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2020 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 05 дугаар тогтоолоор баталсан Үндэсний аудитын газраас гүйцэтгэх аудитын сэдвийг үндэслэн “Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т гүйцэтгэлийн аудитыг гүйцэтгэнэ.
Аудитын зорилт	Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт улсын хэмжээнд нэгдсэн удирдамжаар гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг Улсын Их Хурал болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ. Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэнэ. Үүнд: - Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн тогтолцоо үр нөлөөтэй байгаа эсэх; - Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй байгаа эсэх.
Аудитын хамрах хүрээ	Аудитад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд ТЕЗ-аас эрх шилжүүлж хэрэгжүүлэхээр батлагдсан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий аймгийн Засаг дарга, ЗДТГ, сумд, Орон нутгийн өмчийн газар, ГХБХБГ, төсөл арга хэмжээг хэрэгжүүлэгч компаниуд, ашиглагч байгууллагуудын үйл ажиллагааг хамруулан гүйцэтгэлээ.
Аудитын хязгаарлалт	Цар тахал Covid-19 өвчлөлийн улмаас сумдад хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, ашиглалтын байдлыг газар дээр нь очиж үзэх боломжгүй болж, холбогдох ажилтнуудтай утсаар мэдээлэл солилцон, тайлбар тодруулга авч, ТАХ-ний гүйцэтгэлийн зургийг цахимаар авч ажиллалаа.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг АДБОУС (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит, тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит, гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, МУЕА-ын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “ТАБ-аас аудит хийх журам” гүйцэтгэлийн аудит хийх аргачлалыг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүгнэлт, зөвлөмжийг боловсруулна.

**Аудит хийх багийн
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Ган-Өлзий хянан удирдаж, аудитын менежер У.Оюунтүлхүүр аудитын үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлэн, ахлах аудитор Ч.Ариунаа, аудитор Т.Мөнхтогтох нар гүйцэтгэв.

Аудитын тайлан, судалгааг 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн дотор нэгтгэн, аудитын тайланг холбогдох үе шатны хяналтаар баталгаажуулж, дарга, тэргүүлэх аудиторын 2021 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн А/13 дугаар тушаалаар баталгаажуулж, Үндэсний аудитын газар болон холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүллээ.

Хүндрэл бэрхшээл


Аудит хийх багийн бүрэлдэхүүнд барилгын чиглэлээр мэргэшсэн мэргэжлийн боловсон хүчин байхгүй, мөн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлуудыг гүйцэтгэсний дараа аудитыг хийж байгаа учир ТАХ-г төлөвлөх, гүйцэтгэх явцад аудитын байгууллагаас хяналт хийх, зөрчлийг таслан зогсоох боломжгүй байгаа зэрэг хүндрэл бэрхшээлүүд байна.

Ерөнхий мэдээлэл

Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль, 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр батлагдсан бөгөөд уг хуульд 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдөр нэмэлт өөрчлөлт орсон байна. Уг хуулиар Дорноговь аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 71,739.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 35 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр, 29,965.1 сая төгрөгийг 2020 онд санхүүжүүлэхээр тус тус баталсан байна.

Санхүүжих дүн /сая төгрөгөөр/

График № 1



Тус аймагт хэрэгжих 35 ТАХ-ээс 29 ТАХ-ний эрхийг аймгийн Засаг даргад шилжүүлж, 6 ТАХ-г холбогдох салбарын сайдууд хэрэгжүүлсэн байна.

Салбарын сайдын хэрэгжүүлсэн ТАХ-г тодруулбал:

- ЭХС-ын багц 5,055.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 ТАХ;
- БСШУСС-ын багц 3,200.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 ТАХ;
- БХБС-ын багц 6,356.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 ТАХ;
- ШС-ын багц 10,751.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 ТАХ байна.

Мөн Төсвийн тухай хуулиар батлагдаагүй, салбарын сайдаас эрх шилжүүлсэн 175.0 сая төгрөгийн 2 ТАХ хэрэгжсэн байна.

Дээрх арга хэмжээнүүдийн 40.5 хувийг барилга байгууламж, 21.6 хувийг барилгын засварын ажил, 16.2 хувийг инженерийн шугам сүлжээ, 2.7 хувийг авто зам, 19.0 хувийг тоног төхөөрөмжийн ажил эзэлж байна.

Эрх шилжүүлсэн хөрөнгө оруулалтын 15 ТАХ нь өмнөх оноос шилжиж ирсэн, шинээр хэрэгжих 16 ТАХ-ний 3 ТАХ нь он дамжин санхүүжих ажлууд байна.

Санхүүжилт олгосон байдлыг авч үзвэл гүйцэтгэгч байгууллагад 16,676.2 сая төгрөг, зураг төсвийн санхүүжилт 71.0 сая төгрөг, захиалагчийн хяналтын зардалд 145.5 сая төгрөг, зохиогчид 140.6 сая төгрөг, барьцаа хөрөнгийн дансанд 1,233.2 сая төгрөгийг тус тус шилжүүлсэн байна.

Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтыг өмнөх онтой харьцуулахад ТАХ-ний тоо 33.0 хувиар, санхүүжих дүн 6.0 тэрбум төгрөгөөр буурсан байна.

БҮЛЭГ А. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт орон нутгийн хөгжлийн хэрэгцээ шаардлагад үндэслэж хийгдсэн ч зарим сайдаас хуульд тусгагдаагүй ажлыг хэрэгжүүлсэн байна.

А.1 Сангийн яамнаас хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх, хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр удирдлагын систем www.publicinvestment.gov.mn веб хуудсыг ашиглалтад оруулснаар санхүүжүүлэх үйл явц ил тод, нээлттэй болсон байна.

А.1.1 Жагсаалтад батлагдсан төсөл, арга хэмжээнүүд аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр /2016-2020/, аймгийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд бүрэн тусгагдсан байна.

Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ бүрийг орон нутгийн урт болон дунд хугацааны хөтөлбөрийн бодлогын баримт бичгүүдтэй тулган шалгахад “Хөгжлийн төлөө хамтдаа” аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр /2016-2020/, Аймгийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл зэрэгт тусгагдсан бөгөөд холбогдох хуульд нийцэж байна. Харин “Монгол соёл-Монгол хүмүүн” төсөл хөтөлбөр хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусгагдаагүй бөгөөд уг хөтөлбөрийг БСШУСЯ төлөвлөгөөнд тусгаж, батлуулсан байна.

А.1.2 Жагсаалтад шинээр батлагдсан төсөл, арга хэмжээний 66.0 хувь буюу 14 төсөл арга хэмжээ нь аймгийн ТЭЗ-ийн саналд үндэслээгүй байна.

Аймгийн Засаг даргаас 2019 оны 06 дугаар сарын 04-ний өдөр Төсвийн тухай хуульд¹ заасан хугацаанд салбарын сайд, Сангийн сайд нарт 2020 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 14 төсөл арга хэмжээний саналыг жагсаалтаар гаргаж хүргүүлсэн байна. Дээрх саналаас 2 төсөл арга хэмжээ нь батлагдсан байна. Мөн 2018 онд хүргүүлсэн саналаас 4 төсөл арга хэмжээ нь 2020 онд дэмжигдэж, батлагдсан байна.

Харин орон нутгаас санал хүргүүлээгүй, холбогдох судалгаа, тооцоолол хийгдсэн эсэх нь тодорхойгүй 6,131.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 14 төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр 3,381.0 сая төгрөгийн төсөв батлагдсан байна. /Хавсралт №1/

Орон нутгийн саналд үндэслээгүй батлагдсан ТАХ

Хүснэгт № 1

Д/д	Сайдын нэр	ТАХ-ний тоо	Нийт төсөвт өртөг /сая төгрөг/	2020 онд санхүүжих дүн /сая төгрөг/
1	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд	9	2,824.1	1,624.1
2	Эрүүл мэндийн сайд	2	151.9	151.9
3	Эрчим хүчний сайд	2	1,555.0	1,555.0
4	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	1	1,600.0	50.0
Нийт		14	6,131.0	3,381.0

¹ 29.1-т “хөрөнгө оруулалтын төслийн саналыг төсвийн ерөнхийлөн захирагч бэлтгэж үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад энэ хуулийн 8.4.3-т заасан төсвийн ерөнхийлөн захирагч жилийн төсвийн саналаа жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх”

А.1.3 Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг журмын дагуу эрэмбэлэх ажил хийгдэхгүй байна.

Төсвийн тухай хууль болон журамд зааснаар аймгийн ТЕЗ нь хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний саналыг хүргүүлэхдээ орон нутгийн хэрэгцээ, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг нь тооцон, эрэмбэлсэн байх шаардлагатай.

Дорноговь аймгийн Засаг дарга бөгөөд ТЕЗ нь 2020 онд улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих ТАХ-ний саналаа Засгийн газар, холбогдох Сайдуудад хүргүүлэхдээ аймгийн ИТХТ-ийн хурлаар хэлэлцүүлээгүй буюу Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт хяналт, тайлагналын журам”-ын 3.8² гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

Аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст төсөвт байгууллага болон сумдаас 82,907.3 сая төгрөгийн өртөг бүхий 103 ТАХ-ний санал, хүсэлтийг ирүүлсэн бөгөөд Засаг даргын дэргэдэх Зөвлөлийн хурлаар хэлэлцэж 14 ТАХ-г салбарын сайдад уламжилсан байна.

Төслийн саналыг холбогдох аргачлалд заасан шалгуур үзүүлэлтээр судалж, эрэмбэлээгүй, хэрэгцээ шаардлага, ач холбогдлоор нь үнэлээгүй, үр ашгийг тооцоолгүйгээр холбогдох салбарын сайдад хүргүүлсэн байна.

Өмнөх аудитаар эрэмбэлэх ажил хангалтгүй хийгдэж байгаа зөрчлийг аргилгахаар зөвлөмж хүргүүлсэн ч хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Цаашид Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар батлагдсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох аргачлал”-ыг мөрдөж ажиллах нь зүйтэй байна.

А.2 Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийлгэх ажил Төсвийн тухай хууль батлагдсаны дараа хийгдсээр байна.

А.2.1 Барилга байгууламжийн зураг төсөл зохиох ажлын даалгаврыг хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад үндэслэж боловсруулсан байна.

Дорноговь аймагт Хүүхдийн зуслан байгуулах ажлын даалгаврыг 2020.04.03-ны өдөр, Сайншанд сумын 2 дугаар Сургуулийн 320 суудалтай барилгын өргөтгөл хийх ажлын даалгаврыг 2020.03.23-ны өдөр буюу Төсвийн хууль батлагдан гарсны дараа боловсруулсан байна. Уг 2 ТАХ-ний зураг төсөв нь ажлын даалгаврын дагуу боловсруулагдсан байна.

Тайлант онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 17 төсөл, арга хэмжээний 8 төсөл, арга хэмжээний зураг төсөвт магадлал хийлгэх шаардлагагүй буюу эдгээр төсөл арга хэмжээ нь их засвар, тоног төхөөрөмж нийлүүлэх ажил байна.

² ТЕЗ, аймаг, нийслэл нь тухайн жилийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний төслийг Сайдын зөвлөл, ТЕЗ-ийн удирдлага, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал /ИТХ/-ын тэргүүлэгчдийнхээ хурлаар хэлэлцэж гаргасан холбогдох шийдвэр, тайлбар, танилцуулгын хамт Сангийн яаманд ирүүлнэ.

A.2.2 Зураг төсөл зохиох зардлыг зохиогчийн бодит гүйцэтгэлд үндэслэж олгосон байна.

МУ-ын Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах” журмын 9.17-д “Зураг төсөл боловсруулсан зардал, зохиогчийн хяналт болон захиалагчийн хяналтын зардлыг *тухайн төсөл дээр байгуулсан гэрээ, хийсэн ажлын тайлангийн* дагуу холбогдох норм дүрэмд заасны дагуу олгоно” гэж заасан.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд хэрэгжсэн барилга байгууламж барих 1 ажил, их засварын 8 ажилд зураг төсөв зохиох гэрээ байгуулсан байна.

Зураг төсөл боловсруулах ажилд нийт 71,057.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Зураг төслийн санхүүжилтийг гэрээний гүйцэтгэл, хүлээлцсэн актыг үндэслэн ажил дууссаны дараа олгож байгаа хэдий ч гэрээний хугацаа 5-15 хоног хэтэрсэн 2 ажилд алданги тооцоогүй, санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Дэлгэрэх сумын сургуулийн хичээлийн байрын их засварын ажлын зураг төслийг Барт төсөл ХХК 3.0 сая төгрөгөөр гүйцэтгэсэн бөгөөд зураг төслийг хүлээлгэн өгөөгүй тул санхүүжилт олгоогүй, мөн хүүхдийн зуслан барих ажлын зураг төслийг Шигота ХХК 53.3 сая төгрөгөөр гүйцэтгүүлсэн ч тайлант онд төсвийн тухай хуулиар тус ажлын санхүүжилтийг хассанаас зураг төслийн үнийг олгоогүй байна.

A.2.3 Барилга, байгууламжийн зураг төслийг магадлалаар баталгаажуулсан байна.

МУ-ын Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм"-ийг шинэчлэн баталсан байна. Тус тогтоолын 6.3-т “Барилгын тухай хуулийн 25.2, 25.3, 25.5-д заасан барилга байгууламжийн зураг төсөлд заавал магадлал хийнэ” гэж заасан.

УТХО-аар 2020 онд шинээр барих 3 ажилд магадлалын дүгнэлт, Сайншанд сумын 50 ортой төрөх эмнэлгийн буулгалт, хүчитгэх ажилд магадлалын дүгнэлт гаргуулсан байна.

Төсвийн тухай хууль батлагдсаны дараа магадлалаар баталгаажуулж байгаагаас батлагдсан төсөв хүрэлцэхгүй байх, төсөвт тусгагдаагүй нэмэлт ажил бий болох зэрэг эрсдэл үүссэн байна. Тухайлбал:

- Сайншанд сумын 2 дугаар сургуулийн барилгын өргөтгөл /320 суудал/-ийн ажлын зураг төслийн магадлалын дүгнэлт 2020.05.01-ний өдөр гарсан бөгөөд төсөвт өртөг нь батлагдсан төсвөөс 195.2 сая төгрөгөөр илүү буюу 3,235.5 сая төгрөгөөр хянагдсан байна.
- Төсвийн тухай хуулиар Хүүхдийн зуслан барих ажлын төсөвт өртөг 1,600.0 сая төгрөгөөр батлагдсан байхад магадлалын дүгнэлтээр 2,325.2 сая төгрөгөөр хянагдсан байна. Магадлалын дүгнэлт 2020.08.27-ны өдөр баталгаажсан
- Сайншанд сумын 50 ортой төрөх эмнэлгийн буулгалт, хүчитгэх зураг төслийг магадлалаар хянуулсан боловч төсөвт өртөг нь тодорхойгүй байна.

А.3 Төсөл, арга хэмжээг үр ашигтай төлөвлөх талаар бодитой арга хэмжээ авч ажиллаагүй байна.

А.3.1 Төсөвлөлтийн шаардлагыг хангаагүй төсөл, арга хэмжээг баталсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар зураг төсөл нь батлагдаагүй ТАХ-г хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4³, Газрын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4⁴, Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.3⁵ дэх заалт, Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт тайлагналтын журам”-ын 3.2⁶ дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

Зураг төсөв нь батлагдаагүй 9 ТАХ-г хэрэгжүүлэхээр Төсвийн тухай хуулиар батлуулсан байна.

Ажлын зураг төсөл боловсруулсан байдал

Хүснэгт №2

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Зураг төслийн гэрээний үнийн дүн /сая төгрөг/	Зураг төсөл боловсруулж		Гүйцэтгэгчийн нэр
			Эхэлсэн огноо	Дууссан огноо	
1	Цэцэрлэгийн барилгын их засвар /Сайншанд сум, 1 дүгээр цэцэрлэг/	3.6	2020.01.13	2020.01.17	Сант номун ХХК
2	Сургуулийн барилгын гадна фасад, дээврийн засвар /Сайншанд сум, 5 дугаар сургууль/	4.2	2020.01.15	2020.02.20	Сант номун ХХК
3	Хүүхдийн ордны барилгын их засвар /Сайншанд сум/	4.3	2020.01.15	2020.03.01	Сант номун ХХК
4	Сургуулийн хичээлийн байрын их засвар /Дэлгэрэх сум/	3.0	2020.02.17	2020.03.15	Барт төсөл ХХК
5	Цэцэрлэгийн барилгын их засвар /Иххэт сум/	15.0	2020.02.17	2020.03.20	ТГТ ХХК
6	Сургуулийн барилгын их засвар /Өргөн сум/	6.6	2020.02.17	2020.03.25	Сант номун ХХК
7	Сургуулийн барилгын их засвар /Хатанбулаг сум/	6.8	2020.03.04	2020.04.01	Сант номун ХХК
8	Цэцэрлэгийн дотор хаалга, заслын ажил /Сайншанд сум, 6-р цэцэрлэг/	2.6	2020.03.04	2020.04.01	Сант номун ХХК
9	Хүүхдийн зуслан байгуулах /Дорноговь/	53.2	2020.03.09	2020.05.01	ШИГОТА ХХК
НИЙТ ДҮН		99.3	-		

³ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана

⁴ Хот суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, усан цахилгаан станц байгуулах, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулан газар олгохоос өмнө палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, зөвшөөрөл авсан байна.

⁵ Барилга байгууламжийн техникийн нөхцөл, зураг төсөл боловсруулах, барилгын ажлын зөвшөөрлийг энэ хуулийн 22, 23, 26 дугаар зүйлд заасны дагуу авч, түүнд заасан нөхцөлийг биелүүлэх.

⁶ Тухайн санхүүгийн жилд эхлүүлэхээр төлөвлөж буй барилга байгууламж нь 3.1-т заасан зарчмыг баримталсан байхын зэрэгцээ инженер хайгуулын судалгааг хийж, дүгнэлт гаргасан, зураг төслийг экспертизээр батлуулсан, барилга барих газар болон инженерийн шугам, сүлжээний асуудлыг бүрэн шийдсэн, үр ашигтай нь техник, эдийн засгийн үндэслэл, тооцоогоор нотлогдсон зэрэг барилгын ажлыг эхлүүлэх нөхцөлийг хангасан, урсгал зардлын урьдчилсан тооцоо хийгдсэн байна.

Төсөвлөлтийн шаардлага хангаагүй буюу газрын зөвшөөрөл гараагүй, техникийн нөхцөл олгогдоогүй байхад төсөл, арга хэмжээг хуульд тусгуулдаг зөрчил байсаар байна. Тухайлбал:

- Хүүхдийн зуслан байгуулах /Дорноговь/;
- Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал /Дорноговь, Сайншанд сум, 6 дугаар баг, 2 дугаар сургууль/

Иймд улсын төсвийн хөрөнгө оруулалтад тавигдах шаардлагыг хангаагүй төсөл, арга хэмжээ жагсаалтад батлагдсаар байгаа тул уг зөрчлийг давтан гаргахгүй байх шаардлагатай байна.

А.3.2 Шинээр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний төлөвлөлтөд төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын системээр үр дүнтэй хяналт хэрэгжүүлсэн байна.

Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 6.3 “Төсвийн ерөнхийлөн захирагч нь их засвар, тоног төхөөрөмж, зөвлөх үйлчилгээ зэрэг төсөл, арга хэмжээг төсөвт тусгуулах саналыг албан бичгээр болон цахим системээр дамжуулан Төсвийн тухай хуульд заасан төсвийн цагалбарын дагуу Сангийн яаманд хүргүүлнэ” гэж заасан байдаг.

Сангийн яамны Улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем www.publicinvestment.gov.mn-д 2020 онд шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтыг бүрэн оруулсан байна.

Мөн “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 14.1 “Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг олгохтой холбоотой баримт материалуудыг энэхүү журамд дурдсанаар бүрдүүлж, албан бичгээр Сангийн яаманд хүргүүлэхээс гадна цахим системийн Санхүүжилтийн гүйцэтгэл гэсэн цэсэд оруулж, давхар баталгаажуулж олон нийтэд мэдээлнэ” гэж заасны дагуу хяналтыг хэрэгжүүлж, санхүүжилтийг олгосон байна.

А.3.3 Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг хугацаандаа хэрэгжих боломжгүйгээр баталсан байна.

Төсвийн тухай хуулийн 29.3.5-д “Шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох хэсэг нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож тусгахаар заасан.

Он дамжин хэрэгжих 14 ТАХ-ний санхүүжилтийг хугацаандаа хэрэгжих боломжгүй байдлаар төсвийг баталсан байна.

ТАХ-ний санхүүжилт /сая төгрөгөөр/

Хүснэгт №3

Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	Санхүүж их дүн /2019/	Санхүүж их дүн /2020/	Санхүүж их дүн /2021/
		Эхлэх	Дуусах				
II.1.1.6	Спорт заалны барилга /Өргөн сум/	2019	2020	930.0	400.0	530.0	-
II.1.1.12	Спорт цогцолборын барилга /Хатанбулаг сум/	2012	2020	1,113.4	-	246.6	-
III.1.1.1	Замын-Үүд чөлөөт бүсийн дохиолол, хамгаалалтын нэгдсэн систем /Замын-Үүд сум/	2019	2021	10,751.7	1,000.0	2,000.0	7,751.7


X.1.1.6	Хүүхдийн зуслан байгуулах /Дорноговь/	2020	2021	1,600.0	-	50.0	1,550.0
XI.1.31	Сумын төвийн инженерийн нэгдсэн шугам сүлжээ, барилга байгууламж /Алтанширээ сум/	2019	2020	3,000.0	1,000.0	2,000.0	-
XI.1.32	Сумын төвийн төвлөрсөн дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээ, барилга байгууламж /Хатанбулаг сум/	2019	2020	4,700.0	1,000.0	3,700.0	-
XI.1.33	Сумын төвийн төвлөрсөн дулаан, цэвэр, бохир усны шугам, сүлжээ, барилга байгууламж /Даланжаргалан сум/	2019	2020	2,800.0	700.0	2,100.0	-
XII.1.1.28	Дотуур байрын барилга, 80 ор /Эрдэнэ сум/	2019	2020	1,161.0	500.0	661.0	-
XII.1.1.231	Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал /Сайншанд 2 дугаар сургууль/	2020	2021	3,200.0	-	500.0	2,700.0
XII.1.1.265	Цэцэрлэгийн барилга худалдан авах, 150 ор /Замын-Үүд сум/	2020	2021	1,600.8	-	500.0	1,100.8
XIII.1.1.9	Соёл, спортын төвийн барилга /Айраг сум/	2019	2020	1,190.8	524.6	666.1	-
XIII.1.3.2	“Монгол соёл-Монгол хүмүүн” төсөл хөтөлбөр /Алтанширээ, Сайхандулаан, Өргөн, Даланжаргалан, Айраг, Дэлгэрэх, Иххэт, Мандах сум/	2020	2021	1,500.0	-	300.0	1,200.0
XVIII.1.14	Сумын төвийн шинэчлэлт хөтөлбөрийг хэрэгжүүлэх, эмнэлэг, 100 ор /Замын-Үүд сум/	2013	2020	6,356.0	1,100.0	1,200.0	-
XVIII.1.17	Төрөх эмнэлэг, 50 ор /Сайншанд сум/	2011	2020	8,274.8	2,400.0	2,350.0	-

А.3.4 2020 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээнд хөрөнгө оруулалтын шинж чанартай бус төсөл батлагдаагүй байна.

Тухайн шатны Засаг дарга хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт саналыг Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.3-т “нэг жилийн дотор хэрэгжиж дуусах богино хугацааны хөрөнгийн урсгал засвар, хөрөнгийн шинэчлэл, тоног төхөөрөмж болон бусад хөрөнгийн төслийг хөтөлбөр болон төсвийн ерөнхийлөн захирагчаар тооцож тусгах” гэж заасан байдаг.

Хэрэгжүүлэх ТАХ-ний төрөл, тоо

График №2



Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжиж хэрэгжсэн арга хэмжээнүүдийн 40.5 хувийг барилга байгууламж, 21.6 хувийг барилгын засварын ажил, 16.2 хувийг инженерийн шугам сүлжээ, 2.7 хувийг авто зам, 19.0 хувийг тоног төхөөрөмжийн ажил эзэлж байна.

Эдгээр төсөл арга хэмжээ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24-т хөрөнгө оруулалт гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлага гэж заасантай нийцэж байна.

БҮЛЭГ Б. Захиалагч гэрээний хэрэгжилтийг хугацаанд нь бүрэн хангуулж ажиллаагүй, гэрээний хугацаа хэтрүүлсэн гүйцэтгэгчид хариуцлага тооцоогүй байна.

Б.1 Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулсан байна.

Б.1.1 Эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх боломжтой хугацаанд шилжүүлжээ.

Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар баталсан “ТБОНӨХБАҮХАА-г төлөвлөх, тайлагнах журам”-ын 2.13-т “Захиалагч хуулийн 46.3-т заасны дагуу эрх шилжүүлэх тохиолдолд төсөв батлагдсанаас хойш 60 хоногийн дотор, хэрэв тодотгол орсон бол түүнээс хойш 30 хоногийн дотор тус тус холбогдох албан тушаалтанд шилжүүлсэн байх” гэж заасан.

УТХО-аар 2020 онд шинээр хэрэгжүүлэх 16 ТАХ-ний эрхийг орон нутагт журамд заасан боломжтой хугацаанд шилжүүлсэн байна.

Эрх шилжүүлсэн байдал

Хүснэгт №4

Д/д	ТЕЗ-ийн нэр	ТАХ-ний тоо	ЗГ-ын шийдвэрийн огноо, дугаар	ТЕЗ-ийн шийдвэр, огноо, дугаар	Журамд заасан хугацаанд шилжүүлсэн эсэх
1	БСШУСС	12	2020.01.22, №21	2020.02.06, №1а/734	тийм
2	ЭМС	2	2020.01.22, №21	2020.02.11, №А/90	тийм
3	ХНХС	2	2020.01.22, №21	Цахим бүртгэл 2020.02.03	тийм
Нийт		16	-	-	-

Хүүхдийн ордны барилгын их засвар /Дорноговь/, Хүүхдийн зуслан байгуулах /Дорноговь/ ажлын эрх шилжүүлсэн тухай шийдвэрийг ХНХС-аас ирүүлээгүй бөгөөд цахим бүртгэлээр 2020 оны 02 дугаар 03-ны өдөр шилжүүлсэн байна.

Эрх шилжүүлсэн ажлаас Сайншанд сумын 9 дүгээр цэцэрлэгийн барилгын засварын ажил, Даланжаргалан Соёлын төвийн барилгын засвар /Даланжаргалан сум/ хэрэгжүүлэхгүй байх тухай албан бичгийг БСШУСС-аас ирүүлснээр хэрэгжээгүй байна.

ТАХ-ний хэрэгжүүлэх эрхийг орон нутагт шилжүүлэхдээ хугацаа алдсанаас тендер шалгаруулалт оройтож, төсөл арга хэмжээ он дамжин хэрэгжихэд хүрсэн асуудал гараагүй байна.

Б.1.2 Тайлант онд 16 ТАХ-ний ХАА-г журмын дагуу зохион байгуулсан ч 8 ТАХ гэрээний хугацаанд хийгдээгүйгээс гэрээг сунгасан байна.

Сангийн сайдын 2019 оны 255 дугаар тушаалаар батлагдсан “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”-ын дагуу 2020 оны бүх тендер шалгаруулалтыг цахимаар зохион байгуулжээ.

Тендерийг хуулийн дагуу явуулах үүрэг бүхий үнэлгээний хороог 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр аймгийн Засаг даргын захирамжаар байгуулсан байна.

ТБОНӨХБАҮХАТХ-ийн 47 дугаар зүйлийн 47.6-д Үнэлгээний хорооны гишүүд худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн байна гэж заасан байдаг. Гэтэл худалдан авах ажиллагааны сертификатын хүчинтэй хугацаа дууссан үнэлгээний хорооны гишүүнийг 4 ТАХ-ний тендер шалгаруулалтад оролцуулсан байна.

Мөн Үнэлгээний хорооны гишүүний худалдан авах ажиллагааны сертификат 2020 оны 05 дугаар сард дууссантай холбоотойгоор анхны хуралд оролцож, дараагийн хурлуудад буюу 3 ТАХ-нд хугацаа дууссантай холбоотойгоор оролцоогүй байна.

Энэ нь Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах журмын 4.2-т “үнэлгээний хорооны хуралдаан үнэлгээний хорооны дарга, үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга болон бусад гишүүдийн дийлэнх олонх буюу 75 хувиас дээш ирцтэйгээр хүчин төгөлдөрт тооцогдоно” гэж заасан байдаг ч цаашид үнэлгээний хороо байгуулах шийдвэр гаргахдаа тендер шалгаруулалтын явцад хүчинтэй хугацаа дуусах эрсдэл байгаа эсэхийг нягталж байх шаардлагатай байна. Мөн журмын 2.3-т заасан “үнэлгээний хороо нь сондгой тооны гишүүдтэй байна” гэсэн заалт хэрэгжихгүй байна.

Нийт 17 төсөл, арга хэмжээний 88% буюу 15 төсөл, арга хэмжээг нээлттэй тендер шалгаруулалт, 6% буюу 1 арга хэмжээг харьцуулалт, 6% буюу 1 арга хэмжээг шууд худалдан авалтын аргаар тус тус худалдан авах ажиллагааг зохион байгуулжээ.

Дорноговь аймгийн 2020 онд Худалдан авах бараа, ажил, үйлчилгээний батлагдсан төлөвлөгөөний дагуу 16 ТАХ-г зохион байгуулсан байна.

Гэвч 3 ТАХ буюу Хатанбулаг сумын Спорт цогцолборын барилга, Сайншанд сумын Хүүхдийн ордны барилгын их засвар, Сайншанд сумын Кино театрт тавилга, тоног төхөөрөмж худалдан авах ажлын тендерийн баримт бичгийн шаардлага хангаагүй гэсэн шалтгаанаар дахин тендер зарлаж ХАА-ны ажил сунжирсан байна.

Тухайлбал:

- Хатанбулаг сумын Спорт цогцолборын барилгын тендерийг 2020.06.05-ны өдөр нээхэд тендерийн баримт бичгийн шаардлага хангаагүй учир 2020.06.08-ны өдөр дахин зарлаж 2020.08.05-ны өдөр гэрээ байгуулсан буюу гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааны явцаас хамаарч ажил бүрэн дуусаагүй байна.

ТБОНӨХБАҮХАТХ-ийн 46 дугаар зүйлийн 46.1.8 “барилга, зам, инженерийн шугам сүлжээ зэрэг тодорхой улиралд гүйцэтгэх онцлог шинж чанартай бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг тухайн жилийн төсөв батлагдсан даруйд эхлүүлэх” заалтыг мөрдөж ажиллах.

Өргөн сумын Сургуулийн их засвар, Сайншанд сумын 6 дугаар Цэцэрлэгийн дотор хаалга, заслын 2 ТАХ-ний тендерт шалгарсан Аббадон констракшн ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээ хийхдээ хэрэгжүүлэх хугацааг давхцуулж байгуулсан байна.

Б.1.3 Тендерийн баримт бичгийг хууль, журмын дагуу боловсруулсан байна.

Тендерийн баримт бичгийг худалдан авах ажлын төрөл болон худалдан авах ажиллагааны хэлбэртэй холбоотойгоор Сангийн яамнаас баталсан тендерийн жишиг баримт бичиг, гэрээний маягт болон тендер шалгаруулалтад холбогдох бусад журам аргачлалын дагуу бэлтгэн боловсруулж, тендерийн баримт бичгийг цаасаар болон цахим хэлбэрээр бүрдүүлсэн байна.

Орон нутгийн өмчийн газар нь тайлант оны орлогын төлөвлөгөөг 7.0 сая төгрөгөөр батлуулж, гүйцэтгэлээр цахим тендерийн хураамжаас 8.6 сая төгрөгийн орлого олсон байна.

ТБОНӨХБАҮХАТ хуулийн 10.2-т “50-аас доошгүй хувийг нь бие даан гүйцэтгэхээр ажил гүйцэтгэх тендер ирүүлсэн, орон нутгаас хамгийн их ажиллах хүч авсан хуулийн этгээдийн ажил гүйцэтгэх тендерийн үнийг 7.5 хувиар хийсвэрээр бууруулж тооцон бусад оролцогчийн тендерийн үнэтэй харьцуулж үнэлнэ” гэж заасан байдаг.

ТББ-т заасан дотоодын давуу эрх тооцох шалгуурыг хангаж шалгарсан 6 аж ахуйн нэгж нь аймгийн ХХҮГ-тай Ажиллах хүч авах гэрээ байгуулсан байна.

Орон нутгаас ажиллах хүч авахаар давуу эрх тооцуулсан ААН

Хүснэгт №5

Д/д	Компаний нэр	Гэрээ байгуулсан огноо, дугаар	Авах ажилчдын тоо /тендер тус бүрд/	Авч ажиллуулсан ажилчдын тоо	Тайлан ирүүлсэн эсэх
1	БЭМЭС ХХК	2020.03.25 №11	5-аас доошгүй	3	тийм
2	Зэс орд ХХК	2020.05.01 №26	4-өөс доошгүй	5	тийм
3	Шинэ өрнөлт трейд ХХК	2020.05.27 №27	5-аас доошгүй	16	тийм
4	Дэнжийн хүү ХХК	2020.02.27 №05	5-аас доошгүй	-	үгүй
5	Аббадон констракшин ХХК	2020.04.25 №22	5-аас доошгүй	-	үгүй
6	Фамилипартнерс ХХК	2020.06.10 №33	10-аас доошгүй	-	үгүй
Нийт			30	24	-

Эх сурвалж: Аймгийн ХХҮГ

Хүснэгтээс харахад 3 компани орон нутгаас ажиллах хүч авсан нь тодорхойгүй, гэрээний хэрэгжилтийг тайлагнаагүй байна.

Б.1.4 Тендерт оролцсон компаниудаас 3 ТАХ-нд гомдол гаргажээ.

ТБОНӨХБАҮХАТ хуулийн 21.1-д “Захиалагч тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, худалдан авах ажиллагааны цахим систем болон хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ” гэж заасан байхад 10 хоногт нэг удаа, сард гурван удаа хэвлэгддэг аймгийн “Өнөөгийн Дорноговь” сонинд тендерийн урилгыг нийтэлсэн байна.

2020 оны аймгийн тендер шалгаруулалтын тухай мэдээллийг tender.gov.mn, dornogovi.gov.mn сайтад мэдээлж ажилласан байна.

Үнэлгээний хороо нь борлуулалтын хэмжээ, сүүлийн жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын дундаж өртөг, түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээг зарим ТББ-т өндөр хувиар тооцсон нь тендерт оролцогчийн тоог хязгаарлах нөхцөл үүсгэсэн байна.

Төсөвт өртгийн дүнгээс тооцсон хувь хэмжээ

Хүснэгт №6

№	Оролцогч	Төсөвт өртгийн дүн /сая төгрөг/	Борлуулалтын хэмжээ /орлогын дундаж/	Ижил төстэй ажлын өртөг	Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө, зээлийн хэмжээ	Тендерт оролцогчийн тоо
1	Спорт цогцолборын барилга /Хатанбулаг сум/	246.6	50 хувь 123.3	50 хувь 123.3	50 хувь 123.3	1
2	Цэцэрлэгийн барилга худалдан авах, 150 ор /Замын-Үүд сум/	1,600.0	- -	- -	50 хувь 800.0	1
3	Цэцэрлэгийн барилгын их засвар /Сайншанд сум, 1 дүгээр цэцэрлэг/	165.0	70 хувь 115.5	70 хувь 115.5	70 хувь 115.5	1
4	Цэцэрлэгийн барилгын их засвар /Иххэт сум/	412.1	80 хувь 329.6	80 хувь 329.6	50 хувь 206.1	1

Үнэлгээний хороо тендерт материал ирүүлсэн компанийн материалд нарийвчилсан үнэлгээг хийж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа Хатанбулаг сумын Спорт цогцолборын барилгын ажил, Иххэт сумын Цэцэрлэгийн барилгын их засварын ажил ТАХ-нд техникийн тодорхойлолтын А-д заасан ажил гүйцэтгэх технологи аргачлалыг дутуу ирүүлсэн компаниас нэмэлт тодруулга авч шалгаруулсан боловч Өргөн сумын Сургуулийн барилгын их засварын ажил, Сайншанд сумын 6 дугаар цэцэрлэгийн дотор хаалга, заслын ажил, Дэлгэрэх сумын Сургуулийн их засварын ажилд ажил гүйцэтгэх технологи аргачлалыг ирүүлээгүй гэсэн шалтгаанаар шалгаруулаагүй байна.

Замын-Үүд сумын Цэцэрлэгийн барилгыг худалдан авах ТАХ-г төсөвт тусгуулж, худалдан авах ажиллагааг зохион байгуулсан нь цаг хугацаа, хөрөнгө мөнгө хэмнэсэн боловч өрсөлдөөнийг хязгаарлаж, зөвхөн 1 оролцогчийг сонгон шалгаруулах нөхцөл байдалд хүргэсэн байна.

ТБОНӨХБАҮХАТ хуулийн 55.1-д заасны дагуу 3 ажлын тендерийн үнэлгээтэй холбоотой оролцогчдоос Сангийн яаманд гомдол гаргасан байна.

Тендер шалгаруулалттай холбоотой 2020 онд гарсан гомдол

Хүснэгт №7

№	Гомдол гаргасан огноо	Гомдол гаргагч байгууллага	Тендер шалгаруулалтын нэр	Шийдвэрлэсэн байдал
1	2020.04.02	Цагаан удам ХХК	Дорноговь аймгийн Сайншанд сумын 5 дугаар сургуулийн гадна фасад, дээврийн засварын ажил	Үнэлгээг дахин хийх
2	2020.04.20	Мехатроник ХХК	Сайншанд сумын төрөх эмнэлгийн тоног төхөөрөмж худалдан авах	Үнэлгээг дахин хийх
3	2020.08.14	Сизу ХХК	Хүүхдийн зуслан байгуулах	Үнэлгээг дахин хийх

Эх сурвалж: www.mof.gov.mn – Тендерийн гомдол шийдвэрлэлт /Сангийн яам/

Дээрх маргааныг Сангийн яамнаас ирүүлсэн чиглэлийн дагуу тендер шалгаруулалтын үнэлгээг дахин хийж, 1 ТАХ-ний шалгарсан гүйцэтгэгч өөрчлөгдөж, 2 ТАХ-ний шалгарсан гүйцэтгэгч хэвээр үлдсэн байна.

Дээрх байдлаас үзэхэд гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаанд хууль, журмыг мөрдөж, тендерт оролцогч компаниудаар маргаан гаргахгүйн тулд үнэлгээний хорооны гишүүдийг мэргэжлийн арга зүйгээр ханган, цаашид тендер шалгаруулах ажлыг ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргад зөвлөмж болгов.

ТБОНӨХБАҮХАТХ-ийн 29 дүгээр зүйлийн 29.2-д “гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдсэнээс хойш ажлын 6-аас доошгүй хоногийн дараа, тендер хүчинтэй байх хугацаанд багтааж гэрээ байгуулна” гэж заасан байхад Сайншанд сумын 6 дугаар цэцэрлэгийн дотор хаалга, заслын ажил 2 хоног, Замын-Үүд сумын Цэцэрлэгийн барилга худалдан авах ажил 3 хоногийн дараа гэрээ байгуулсан байна.

Б.1.5 ТЕЗ худалдан авах ажиллагааны тайланг хугацаанд нь тайлагнасан байна.

Дорноговь аймгийн Орон нутгийн өмчийн газар нь худалдан авах ажиллагааны тайланг Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар батлагдсан журмын 3.1⁷-д заасан хугацаанд буюу хагас, бүтэн жилээр Сангийн яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлжээ.

Сангийн яамнаас тус аймгийн Худалдан авах ажиллагааны 2020 оны хэрэгжилтэд “81.0” буюу “сайн” гэсэн үнэлгээ өгсөн байна

Б.2 Захиалагч гэрээний хэрэгжилтийг хугацаанд нь бүрэн хангуулж ажиллаагүй байна.

Б.2.1 Захиалагч гэрээний хугацаа хэтрүүлсэн гүйцэтгэгчид хариуцлага тооцоогүй байна.

Дорноговь аймагт 2020 онд 37 ТАХ хэрэгжсэн бөгөөд үүний 13 ТАХ-ний гэрээний хугацааг сунгасан байна. Гэрээний хугацаанд өөрчлөлт оруулсан боловч хугацаандаа дуусгаагүй зөрчил байсаар байна. Мөн тайлант онд хийгдсэн 5 их засварын ажлын гэрээний хугацааг сунгасан байна.

ТАХ хугацаандаа хэрэгжихгүй байгаа нь нэг гүйцэтгэгч олон ажилд зэрэг шалгарсан, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа боловсон хүчний хүрэлцээ, чадавхыг тооцоогүй, он дамжин санхүүжих ажлыг тухайн онд дуусгахаар гэрээ байгуулдаг, инженер геологийн судалгааны ажлыг чанаргүй гүйцэтгэснээс нэмэлт ажил хийгддэг, зураг төсөл ТЭЗҮ, инженер геологийн ажил хийгдээгүй байхад төсөв батлагдсан зэрэг нь голлон нөлөөлсөн байна. Тухайлбал:

- Өргөн сумын сургуулийн барилгын их засвар, Сайншанд сумын 6 дугаар цэцэрлэгийн барилгын засварын ажилд Аббадон констракшн ХХК шалгарч, гэрээний гэрээний хугацааг 1-2 сараар сунгасан;
- Алтанширээ, Даланжаргалан, Хатанбулаг сумдад төвлөрсөн дулаан, цэвэр бохир усны шугам сүлжээ барих ажлын гэрээний хугацааг сунгасан ч ажил хугацаандаа дуусаагүй 2-4 сараар хэтэрсэн байна. Энэ нь геологийн судалгааны ажил хангалтгүй хийгдсэнээс трассын дагуу суваг шуудууны 50 хувьд хөрсний ус илэрч, хөрсний усыг соруулах, шавар шавхайг хатаах зэрэг ажилд төлөвлөсөн хугацаанаас 2 дахин хугацаа зарцуулсан /Алтанширээ сум/, зураг төсөвт төлөвлөгдсөн уст цэгт өрөмдлөг хийхэд ус илрээгүй, 3.2 км-ийн зайд цэвэр ус илэрсэн цэг хүртэл хос цэвэр усны шугам татахаар төлөвлөсөн /Хатанбулаг сум/-тэй холбоотой байна;
- Улаанбадрах, Хөвсгөл, Айраг сумдад соёл, спортын төвийн барилга баригдсан бөгөөд гэрээний хугацаа 1-9 сараар хэтэрсэн нь барилгын анхны төлөвлөсөн байршлын доор улсын чанартай шилэн кабел, цэвэр усны сүлжээ таарсан, улмаар гадна цахилгаанаар хангах техникийн нөхцөл удааширсан, барилгын гадна дулаан шийдэгдээгүйн улмаас дотор заслын ажлыг халаагуур суурилуулж хүйтний улиралд гүйцэтгэсэн /Улаанбадрах сум/, барилгын санхүүжилт он дамжин батлагдсан, барилгын анхны зургаар төлөвлөгдсөн газрын байршил өөрчлөгдсөнөөс шалтгаалж ерөнхий төлөвлөгөө, өндөржилт, суурийн зурагт өөрчлөлт орсон /Хөвсгөл сум/ зэрэг нөлөөлсөн байна.

⁷ 3.1.1 хагас жилийн тайланг тухайн оны 7 дугаар сарын 15-ны өдрийн дотор;

3.1.2 бүтэн жилийн тайланг дараа оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн дотор;

Гүйцэтгэгч ажлаа бүрэн дуусаагүй байхад ашиглалтад оруулах хүсэлтийг захиалагчид хүргүүлдэг, комисс ажиллахад ажил бүрэн хийгдээгүй, комиссоос олон үүрэг даалгаврыг өгснөөс хугацаандаа хэрэгжихгүй байх нөхцөл үүссэн байна. Тухайлбал:

- Алтанширээ суманд төвлөрсөн дулаан, цэвэр бохир усны шугам сүлжээ барих ажлын гүйцэтгэгч Б-Софт ХХК улсын комисс оруулах хүсэлтийг 3 удаа өгсөн бөгөөд комисс ажиллаад 106 зөвлөмжийг өгсөн ч ажил гэрээний хугацаанд бүрэн дуусаагүй байхад ашиглалтад хүлээн авсан;
- Даланжаргалан суманд төвлөрсөн дулаан, цэвэр бохир усны шугам сүлжээ барих ажлын гүйцэтгэгч Илчит сансар ХХК;
- Хатанбулаг суманд төвлөрсөн дулаан, цэвэр бохир усны шугам сүлжээ барих ажлын гүйцэтгэгч Одкон холдинг ХХК;
- Улаанбадрах сумын соёл, спортын төвийн барилга барих ажлын гэрээний хугацаа 9 сараар хоцорсон;
- Хатанбулаг сумын сургуулийн барилгын их засварын ажлын гэрээний хугацаа 26 хоногоор хоцорсон байхад алданги тооцоогүй байна.

Б.2.2 Захиалагч, зохиогчийн хяналтаар илэрсэн зөрчлийг гүйцэтгэгчээр тухай бүрд нь арилгуулсныг нотлох баримт, материал хангалтгүй байна.

Захиалагчийн хяналт хэрэгжүүлэх үйл ажиллагааг Засгийн газрын 2017 оны 170 тоот тогтоолоор батлагдсан Барилгын ажлын захиалагчийн дүрмээр зохицуулж байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд хийгдсэн ажлуудын захиалагчийн хяналтыг ГХБХБГ гүйцэтгэхээр аймгийн Засаг даргатай 8 гэрээг шинээр, он дамжин хэрэгжиж буй 12 ТАХ-ний гэрээг 2019 онд тус тус байгуулсан байна.

Захиалагчийн хяналтыг гэрээнд тусгасны дагуу хэрэгжүүлдэг боловч захиалагч байгууллагаас өгсөн үүрэг, тавьсан шаардлага, зөвлөмжийг хэрхэн биелүүлсэн талаар дүгнэлт гаргах ажил хангалтгүй, гүйцэтгэгч байгууллага өгсөн шаардлага, зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлсэн талаар албан ёсоор өгсөн баримт материал байхгүй байна. Тухайлбал:

- Замын-Үүд сумын 150 хүүхдийн цэцэрлэгийн барилга барих ажилд ГХБХБГ 10 удаагийн хяналтыг хэрэгжүүлсэн гэх боловч барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн тэмдэглэлд 6 удаагийн хяналт бичигдсэн,
- Мандах сумын 100 хүүхдийн цэцэрлэг барих ажилд 8 удаагийн хяналт хийгдсэн гэх боловч 4 удаагийн хяналтыг тэмдэглэлд бичсэн
- Айраг сумын соёл, спортын төвийн барилга угсралтын ажилд 10 удаагийн хяналт хэрэгжүүлж, 5 удаа тэмдэглэл үйлдсэн байна.

Дээрх ажлуудын барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн тэмдэглэл буюу улаан дэвтэрт захиалагчийн хяналтаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх хугацааг тодорхой тусгаагүй, хэрэгжилтийг дүгнээгүй, гүйцэтгэгч биелэлтийг гаргаагүй зэрэг зөрчил нийтлэг байна.

Зохиогчийн хяналтыг Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 178 дугаар тушаалаар батлагдсан "Барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт тавих дүрэм"-ээр зохицуулж байна.

Тайлант онд зохиогчийн хяналтыг хэрэгжүүлэхээр 2020 онд 12 гэрээг шинээр, 10 гэрээг 2019 онд байгуулжээ.

Зохиогчийн хяналтын гэрээнд барилга, байгууламж шинээр барих ажлын үе шат бүрд 8-12 удаа хяналт тавиулахаар, их засварын ажлуудад 3-5 удаа хяналт тавихаар тусгасан байна.

Гэрээнд “Гүйцэтгэгч нь зохиогчийн хяналт хийх бүрд талбайн журналд тэмдэглэл хийж, аймгийн ГХБХБГ-ын Барилга хот байгуулалтын хэлтэст хяналт хийсэн тухай бүр зохиогчийн хяналтын тайланг албан ёсоор ирүүлнэ” гэж заасан боловч хэрэгжилт хангалтгүй байна. Тухайлбал:

- Соёл, спортын төвийн барилга /Хөвсгөл сум/-ын зохиогчийн хяналтыг ТГТ ХХК хэрэгжүүлсэн бөгөөд гэрээнд барилга угсралтын ажлын үе шат бүрд нийт 12 удаагийн хяналт хэрэгжүүлэхээр тусгасан боловч улаан дэвтэрт 5 удаагийн зөвлөмж бичигдсэн, зөвлөмжийг хэрхэн хэрэгжүүлснийг дүгнээгүй, захиалагчид хяналт хийсэн дүгнэлт бичиж өгөөгүй
- Соёл, спортын төвийн барилга /Айраг сум/-ын зохиогчийн хяналтыг ТГТ ХХК хэрэгжүүлсэн, гэрээнд 12 удаагийн хяналт хэрэгжүүлэхээр тусгасан ч талбайн журналд 6 удаагийн хяналт хийсэн талаар тэмдэглэсэн, зөвлөмжийн биелэлтийг дүгнээгүй
- Сумын төвийн инженерийн нэгдсэн шугам сүлжээ, барилга байгууламж /Алтанширээ сум/-ын зохиогчийн хяналтыг Монкузбасс ХХК гүйцэтгэсэн бөгөөд 8 удаагийн хяналт хэрэгжүүлэх байтал 5 удаагийн хяналтыг талбайн журналд тэмдэглэсэн байна.

Мөн зохиогчийн хяналтын гэрээг дүгнэхдээ *хяналт хэрэгжүүлэхээр тохиролцсон тоо*, гүйцэтгэлийн үр дүнг харгалзан *зохиогчийн хяналтын нэгдсэн дүгнэлт* болон зохиогчийн хяналт хийсэн талаарх *гэрээ дүгнэсэн актыг үндэслэн* зохиогчийн хяналтын зардлыг санхүүжүүлэхээр заасан ч гэрээ дүгнэх ажил нь хангалтгүй байна. Ихэнх тохиолдолд ГХБХБГ-аас ирүүлсэн албан бичиг, зохиогчийн хяналтын тайланг үндэслэн санхүүжилтийг олгосон байна.

Б.2.3 Хөрөнгө оруулалтаар авсан тоног төхөөрөмж хэрэглэгчдэд бүрэн хүрсэн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд 603.5 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн байна. Тодруулбал ЭМС-аас 122.5 сая төгрөг, БСШУСС-аас 481.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Тоног төхөөрөмжийн жагсаалт /мянган төгрөг/

			Хүснэгт №8
№	Сайдын багц	ТАХ-ний нэр	Олгосон санхүүжилт
1	БСШУСС	Дорноговь аймгийн Сайншанд сумын 13 дугаар цэцэрлэгт тавилга, тоног төхөөрөмж нийлүүлэх	9,669.1
2	БСШУСС	Кино театрын барилгын тоног төхөөрөмж /Дорноговь, Сайншанд сум/ багц-2	138,238.1
3	БСШУСС	Кино театрт тавилга, тоног төхөөрөмж худалдан авах /Дорноговь Сайншанд/	138,895.0
4	БСШУСС	Сургуулийн гал тогооны тоног төхөөрөмж /Дорноговь, Сайншанд сум, 1, 2, 5 дугаар сургууль/	194,210.0
5	ЭМС	Төмөр замын эмнэлгийн тоног төхөөрөмж /Дорноговь, Сайншанд сум, 4 дүгээр баг/	33,572.0
6	ЭМС	Төрөх эмнэлгийн тоног төхөөрөмж /Дорноговь, Сайншанд сум, 2 дугаар баг/	89,000.0
Дүн			603,584.2

Хөрөнгө оруулалтаар авсан тоног төхөөрөмж захиалагчийн бэлтгэсэн техникийн тодорхойлолтын дагуу хэрэглэгчдэд бүрэн хүрсэн ч ижил төрлийн барааг үнийн хувьд харилцан адилгүй нийлүүлсэн, зарим тоног төхөөрөмжийг зах зээлийн үнээс хэт өндрөөр нийлүүлсэн байна.

- Сайншанд сумын 1, 2, 5 дугаар сургуульд гал тогооны тоног төхөөрөмж нийлүүлэх ажлыг Тулга төхөөрөмж ХХК гүйцэтгэсэн бөгөөд ижил төрлийн барааг үнийн зөрүүтэй нийлүүлсэн.

Тоног төхөөрөмжийн жагсаалт /мянган төгрөг/

Хүснэгт №9

Ашиглагч байгууллага	Тоног төхөөрөмжийн нэр	Үнэ
1 дүгээр сургууль	2-р хоолны тогоо /70 л/	4,400.0
5 дугаар сургууль		4,200.0
Зөрүү		200.0
1 дүгээр сургууль	Хөргөгч /4 хаалгатай/	2,000.0
2 дугаар сургууль		2,180.0
Зөрүү		180.0
1 дүгээр сургууль	Дээжийн хөргөгч	438.0
5 дугаар сургууль		368.0
Зөрүү		70.0
2 дугаар сургууль	Гурил хайрагч	398.0
5 дугаар сургууль		450.0
Зөрүү		52.0
2 дугаар сургууль	Лангуун хөргүүр /1800мм урт/	2,200.0
5 дугаар сургууль		2,100.0
Зөрүү		100.0
2 дугаар сургууль	Бантан зуурагч	800.0
5 дугаар сургууль		900.0
Зөрүү		100.0

- Монгол соёл-Монгол хүмүүн төслийн хүрээнд нийлүүлсэн лед дэлгэцийг Алтанширээ суманд 20 инчийг 54.3 сая төгрөгөөр, Дэлгэрэх, Иххэт сумдад 24 инчийг ижил үнээр буюу 54.3 сая төгрөгөөр нийлүүлсэн байна.
- Кино театрт тавилга, тоног төхөөрөмж худалдан авах ажлыг Саннисервис ХХК гүйцэтгэсэн бөгөөд зах зээлийн үнээс хэт өндрөөр нийлүүлсэн байна.

Тоног төхөөрөмжийн жагсаалт /мянган төгрөг/

Хүснэгт №10

№	Хөрөнгийн нэр	Саннилайф ХХК	ITzone	Cybercom	Үзүүлэлт
1	Оффисын суурин компьютер /All in one/	3,346,498	-	2,719,000	Acer Aspire C22-866 i5-8250U 8192MB RAM
2	3 үйлдэлт принтер	2,226,899	1,522,200	1,497,000	Canon imageClass MF269dw
3	Өнгөт принтер	1,592,849	1,006,900	1,216,000	Image Class LBP 621Cw
4	Ус буцалгагч	900,000	-	495,000	Elko

Б 2.4 Зураг төслийн санхүүжилтэд 85,057.0 мянган төгрөг олгосон байна.

Тус аймагт 2020 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барилга угсралтын 3 ажил шинээр, барилга байгууламжийн их засварын 9 ажил хэрэгжсэн байна.

Их засварын ажлын зураг төслийг Сант номун ХХК, ТГТ ХХК, Барт төсөл ХХК-ууд гүйцэтгэсэн бол Хүүхдийн зулсан барих ажлын зураг төслийг Шигота ХХК, Сайншанд сумын 2 дугаар сургуулийн барилгын өргөтгөлийн барилгын зураг төслийг ТГТ ХХК тус тус гүйцэтгэсэн байна.

Зураг төслийн санхүүжилтэд нийт 85,057.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон бөгөөд нэг маягийн зураг төсөл ашигласан арга хэмжээ байхгүй байна.

Сангийн сайдын 2019 оны 282 тоот тушаалд зураг төсөл боловсруулсан зардлыг олгохдоо хавсралт №16-д заасан гүйцэтгэлийн актыг үйлдэж олгохоор заасан ч хэрэгжүүлээгүй байна.

Б.3 Захиалагч, зохиогчийн хяналтаар өгсөн зөвлөмж, үүрэг даалгаврын биелэлтийг дүгнэх үйл явц хангалтгүй байна.

Б.3.1 Захиалагчийн болон зохиогчийн хяналтыг барилга угсралтын үе шат бүрд хэрэгжүүлсэн ч хяналтаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг дүгнэх, баримтжуулах үйл явц хангалтгүй байна.

Зураг төсөл боловсруулсан зардал, зохиогчийн хяналт болон захиалагчийн хяналтын зардлыг тухайн төсөл дээр байгуулсан гэрээ, хийсэн ажлын тайлангийн дагуу холбогдох норм дүрэмд заасныг үндэслэн олгохоор журамласан байна.

Аймгийн ЗДТГ захиалагчийн хяналтын зардлын 70 хувийг ГХБХБГ-т олгож, үлдэгдэл 30 хувийг нэмэлт санхүүжилтийн дансанд авч зарцуулж байна. ГХБХБГ-т 2020 онд нийт 102.3 сая төгрөгийн захиалагчийн хяналтын зардлыг олгож, АЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд 43.3 сая төгрөгийг захиалагчийн хяналтын зардал нэрээр төвлөрүүлсэн байна.

Барилга байгууламж, их засварын ажлын захиалагчийн хяналтыг ГХБХБГ-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлжээ. Харин зам, гүүрний мэргэжлийн ажилтан байхгүйгээс автозамын хяналтыг тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлсэн байна.

Захиалагч гүйцэтгэгчийн ирүүлсэн барилга угсралтын ажлын үе шатны ажлын хуваарийг баталж, үе шат бүрд хяналт хэрэгжүүлсэн боловч түүнийг нотлох баримтын бүрдэл хангалтгүй байна. Тухайлбал:

-Захиалагч барилгын үе шатны ажлын гүйцэтгэлийн тэмдэглэл, ил далд ажил болон тоног төхөөрөмжийн туршилт, тохируулга хийсэн акт, ажил гүйцэтгэх төлөвлөгөөг хянаж баталгаажуулаагүй байна.

-Зохиогчтой барилгын үе шат бүрд хяналт тавихаар гэрээ байгуулсан боловч зохиогчийн хяналтын тэмдэглэл, дүгнэлт үйлдэх ажил хангалтгүй хийгдсэн байна.

Б.3.2 Зарим ТАХ-ний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэж олгоогүй байна.

Сангийн сайдын 2019 оны 282 тоот тушаалаар Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журмыг баталсан бөгөөд тус журамд барилга байгууламжийн ажлын санхүүжилт, их засвар, тоног төхөөрөмжийн санхүүжилт, зөвлөх үйлчилгээний санхүүжилт зэргийг хэрхэн олгох талаар тодорхой тусгасан байна.

Захиалагч барилга угсралтын ажлын календарчилсан төлөвлөгөө, ажлын бодит гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилтийг олгож байгаа ч бодит гүйцэтгэлд үндэслээгүй дараах ажлын санхүүжилтийг олгосон байна.

- Монгол соёл- Монгол хүмүүн хөтөлбөр 8 суманд хэрэгжсэн бөгөөд гүйцэтгэлийг 2020 оны 10 дугаар сард баталгаажуулж нийт 300.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгожээ. Гүйцэтгэлд аймгийн СТСХ-ийн дарга, ХОХБТХ-ийн ахлах мэргэжилтэн, СТСХ-ийн ерөнхий санхүүч, ашиглагч байгууллагын дарга зэрэг албан тушаалтууд гарын үсэг зурсан байхад тухайн ТАХ-ний хүрээнд нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийг 2021 оны 3 дугаар сард хүлээн авч суурилуулсан, гүйцэтгэгч сургуулийн байгалийн ухааны кабинетын засварын ажлын гүйцэтгэлийг 8 суманд ижил хэмжээтэй анги засварласан мэтээр гүйцэтгэлийг гаргасан, нийт 10.2 сая төгрөгийн 8 ангийн жалюзан хөшиг нийлүүлээгүй, нийт 1.4 сая төгрөгийн 4 ширхэг хаалга, 4.6 сая төгрөгийн 6 ангийн вакум цонхыг суурилуулаагүй байна. Мөн захиалагч, зохиогчийн хяналтын зардал, магадалшгүй ажлын зардал зэрэг нийт 5.5 сая төгрөгийг гүйцэтгэгчид олгосон байна.

- Төсвийн тухай хуулиар Сайншанд суманд баригдсан 50 ортой төрөх эмнэлгийн санхүүжих дүнг 2,350.0 сая төгрөгөөр баталсан байхад СЯ-аас 4,074.1 сая төгрөгийн санхүүжилтийн эрх нээсэн, бодит гүйцэтгэл гараагүй байхад гүйцэтгэгч буюу Баярсонстракшн ХХК-д 3997.9 сая төгрөгийн санхүүжилт олгосон /аудитын байгууллагад гүйцэтгэлийг ирүүлээгүй/
- Замын-үүд суманд 150 хүүхдийн цэцэрлэгийн барилгыг 1,539.0 сая төгрөгөөр худалдан авах гэрээг байгуулж, тайлант онд 500.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар худалдан авах барилга, байгууламжид тавих шаардлагыг тогтоож өгсөн боловч үл хөдлөх хөрөнгийн болон газар эзэмших эрхийн гэрчилгээг захиалагч эсхүл ашиглагч байгууллагын өмчлөлд шилжүүлсэн байх шаардлага хангагдаагүй. Мөн барилгын чанар, стандарт нь ашиглалтын шаардлага хангаж байгаа талаар дүгнэлт гаргуулсан байхаар заасан байхад аймгийн МХГ-аас урсгал засвар хийх шаардлагатай гэсэн дүгнэлтийг гаргасан байв.
- Сайншанд сумын 2-р сургуулийн барилгын өргөтгөлийн ажлыг 3,040.3 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр БСШУСЯ гэрээ байгуулсан бөгөөд тайлант онд 500.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Захиалагчийн хяналтыг Барилгын хөгжлийн төв гүйцэтгэсэн бөгөөд үе шатны ажлын хуваариар 2020 оны 9 дүгээр сард суурь, каркас, хамар ханын ажил дууссан байхаар төлөвлөсөн боловч суурийн ажил л хийгдсэн байна.
- Хатанбулаг сумын Спорт цогцолборын барилгын ажлыг дуусгуулахаар Шинэ-Өрнөлт трейд ХХК-тай гэрээ байгуулсан бөгөөд эцсийн гүйцэтгэлийг баталгаажуулж, санхүүжилт олгосон байхад дээвэр, гадна фасадын ажил хийгдээгүй, дулааны улиралд гүйцэтгэх даалгавар өгсөн
- Эрдэнэ сумын дотуур байрын барилга /80 ор/ барих ажлыг Тобэм ХХК 1,148.5 сая төгрөгөөр гүйцэтгэхээр гэрээ байгуулсан бөгөөд гэрээ байгуулснаас хойш 20 хоногийн дараа 500.0 сая төгрөгийн гүйцэтгэл хянуулж санхүүжилт авсан байна.

Б.3.3 Хөрөнгө оруулалтын үйл явцад дотоодын хяналт тавих чиг үүрэг хэрэгжихгүй байна.

МУ-ын Төсвийн тухай хуульд Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулахаар заасан байна.

СХАА-ны аймгийн Засаг даргаар батлуулсан 2020 оны хяналт шалгалтын төлөвлөгөөнд УТХО-аар хийгдсэн ажлын үр дүнд хийх хяналт шалгалт тусгагдаагүй, УТХО-аар хийгдсэн ажлын үр дүнд хяналт шалгалт хийгээгүй байна.

Мөн Сангийн сайдын 2019 оны 282 тоот тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 15.4-т Сангийн яам төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилтийн зориулалтын байдалд хяналт тавьж, шаардлагатай бол барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмж худалдан авах, зөвлөх үйлчилгээний ажилд шалгалт хийж, зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээ авна гэж заасан боловч СЯ-аас орон нутагт хяналт шалгалт хийгдээгүй байна.

Б.4.1 Гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг бүрэн хангуулах үүднээс чанарын баталгааны 5 хүртэлх хувийг барьцаа төлбөрийн дансанд байршуулдаг болсон байна.

Тус аймагт хэрэгжсэн төсөл арга хэмжээний санхүүжилтийг олгохдоо барьцаа хөрөнгийн данс болон урьдчилгаа төлбөрийн баталгаагаар олгосон санхүүжилт байхгүй байна.

Харин ТБОНӨХБАҮХАТХ-ийн 43 дугаар зүйлийн 43.6 “Бараа, ажил, үйлчилгээний чанарын баталгаат болон зүгшрүүлэх тохируулах хугацаанд гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гэрээний үнийн дүнгийн 5-10 хувийг уг хугацаа дуустал барьцаалах нөхцөлийг захиалагч тендерийн баримт бичигт тусгаж болно” гэж заасныг үндэслэн барьцаа төлбөрийн данс нээсэн байна.

Сүүлийн жилүүдэд тус аймагт томоохон барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний ажил хийгдсэн бөгөөд тэдгээрийг зүгшрүүлэх, тохируулах хугацаанд чанарын баталгааны 5 хувийг авч үлдэж байгаа нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг бүрэн хангуулахад түлхэц болсон байна.

Тус барьцаа хөрөнгийн дансанд УТХО-аар хийгдсэн ажлын 1,233.2 сая төгрөгийг байршуулсан байна.

Б.4.2 Барилга, байгууламж, тоног төхөөрөмжийн үнэ тодорхой бус байгаагаас бүртгэлд тусгаагүй, хөрөнгийн хэрэгцээ шаардлагыг оновчтой тодорхойлоогүйгээс их хэмжээний ашиглалтгүй хөрөнгө бий болсон байна.

Барилгын тухай хуулийн 35.1.4 “Аймгийн Засаг дарга нь тухайн нутаг дэвсгэрт байрлах барилга байгууламжийн ашиглалтад хяналт тавьж, бүртгэх, паспортжуулах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасан.

Барилга, байгууламжийг данс бүртгэлд тусгах үнэ тодорхой бус, оны эцэст ашиглалтад хүлээн авах комиссын дүгнэлт гарснаас тухайн ондоо багтаж бүртгэлд тусгах шийдвэр гараагүй зэргээс шалтгаалан 2020 онд ашиглалтад орсон дараах барилга, байгууламж, тоног төхөөрөмжийг данс бүртгэлд тусгаагүй байна.

- Мандах суманд баригдсан 874.0 сая төгрөгийн өртөг бүхий 75 ортой хүүхдийн цэцэрлэгийг 2020 оны 12 дугаар сард ашиглалтад хүлээн авсан, тухайн ондоо бүртгэлд тусгаагүй.
- Улаанбадрах суманд баригдсан 1,089.5 сая төгрөгийн өртөг бүхий соёл, спортын төвийн барилгыг оны эцэст хүлээн авснаас тухайн ондоо данс бүртгэлд тусгаагүй.
- Олон жил он дамжин хэрэгжсэн Замын-Үүд сумын 100 ортой эмнэлэг, Сайншанд суманд баригдсан төрөх эмнэлгийн барилгын төсөвт өртөг тодорхой бус, данс бүртгэлд тусгах шийдвэр гараагүй зэргээс өнөөдрийг хүртэл данс бүртгэлд тусгаагүй.
- Монгол соёл-Монгол хүмүүн хөтөлбөрийн хүрээнд 8 сумын сургуулийн биологийн танхимыг тохижуулж, соёлын төвүүдэд лед дэлгэц, сургалтын зориулалттай гэр нийлүүлсэн боловч бүртгэлийн үнэ тодорхой бус, гүйцэтгэгч байгууллага данс бүртгэлд тусгах анхан шатны баримтыг өгөөгүйгээс нэг бүр нь 54.3 сая төгрөгийн өртөг бүхий лед дэлгэцийг Иххэт, Дэлгэрэх, Алтанширээ сумд данс бүртгэлд тусгаагүй, 4.2 сая төгрөгийн өртөг бүхий сургалтын гэрийг Айраг, Даланжаргалан сумд данс бүртгэлд тусгаагүй.
- Сайншанд сумын 5 дугаар сургууль нэг бүр нь 368.0 мянган төгрөгийн үнэ бүхий 3 ширхэг дээжийн хөргөгчийг данс бүртгэлд тусгаагүй байна.

Иргэдийн ая тухтай амьдрах орчин нөхцөлийг сайжруулахад чиглэсэн олон бүтээн байгуулалт, барилга байгууламж баригдсан ч тухайн хөрөнгө оруулалтыг төлөвлөхдөө ирээдүйд хүртэх үр өгөөж, хэрэгцээ шаардлага, цаашид гарах урсгал болон ашиглалтын зардлыг урьдчилж тооцоогүйгээс ашиглалтгүй хөрөнгүүд бий болсон байна. Тухайлбал:

- Улаанбадрах, Хөвсгөл, Айраг сумдад 200 хүний суудалтай соёл, спортын төвийн барилга баригдсан бөгөөд ашиглалт хангалтгүй, 5-6 хүний орон тоотой байдаг соёлын төвийн урсгал зардал их хэмжээгээр нэмэгдсэн, өмнө ашиглаж байсан барилга, байгууламжийг хэрхэн авч явах нь тодорхой бус үхмэл хөрөнгө бий болсон байна.
- Сумын төвийн төвлөрсөн дулаан, цэвэр бохир усны шугамын ажил Алтанширээ, Даланжаргалан, Хатанбулаг сумдад хийгдсэн бөгөөд одоогоор ашиглалт мөн л бага, сумын төвийн 6-8 төсөвт байгууллага тус шугам сүлжээнд холбогдсон байна.

- Шинээр ашиглалтад орсон Сайншанд сумын төрөх эмнэлэгт 89.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн байна. Үүний 51.1 сая төгрөгийн 5 ширхэг тоног төхөөрөмж ашиглалтгүй байна. Нэг бүр нь 1.8 сая төгрөгийн өртөг бүхий 3 ширхэг дуслын автомат шахуурга нь минутын тохиргоо суугдаагүйгээс ашиглах боломжгүй болсон. Мөн 41.7 сая төгрөгийн 4D эхо аппарат программ суугдаагүй, хэвлэх төхөөрөмж дагалдаж ирээгүй, датчик нь 2 D учраас ашиглалтын шаардлага хангахгүй зэргээс ашиглаагүй. ЭКГ буюу зүрхний цахилгаан бичлэгийн аппарат 3.9 сая төгрөгөөр нийлүүлэгдсэн бөгөөд программын тохиргоо алдаатай хийгдсэнээс мөн ашиглалтгүй байна.



Зураг №1




Зураг №2

- Кино театрт тавилга, тоног төхөөрөмж худалдан авах ажлыг 138.9 төгрөгөөр гүйцэтгэсэн бөгөөд хөрөнгийн хэрэгцээ шаардлагыг бодитой төлөвлөөгүйгээс ашиглалт хангалтгүй байна. Тухайлбал:

- Кино театрын барилга ОНӨГ-т бүртгэлтэй байдаг бөгөөд түрээслэгч зарим хөрөнгө, тоног төхөөрөмжийг ашиглах шаардлагагүй гэж үзсэнээс ОНӨГ 12 нэр төрлийн 16.1 сая төгрөгийн хөрөнгийг ашиглаж байна. Мөн аймгийн ИТХ-ын шийдвэрээр нийт 21.0 сая төгрөгийн өртөг бүхий нам яригч, шингэн яригч, чадлын өсгөгч, зурвас хуваарилагчийг БТСГ-т шилжүүлсэн, 3.3 сая төгрөгийн суурин компьютерыг ЭЭС ОНӨХХК-д тус тус шилжүүлсэн байна. Мөн 5.8 сая төгрөгийн өртөг бүхий өнгөт принтер, суурин компьютер, дэлгэц зэргийг ашиглаагүй агуулахад хадгалж байна.



Зураг №3



Зураг №4



Зураг №5

- Сайншанд сумын 1,2,5 дугаар сургуулийн гал тогоонд тоног төхөөрөмж нийлүүлэх ажил 194.2 сая төгрөгөөр хийгдсэн бөгөөд хэрэгцээ шаардлагыг бодитой тооцоогүйгээс ашиглалтгүй хөрөнгө шинээрээ хадгалагдаж байна. Тухайлбал:

- **1 дүгээр сургууль:** 13 нэр төрлийн 39.3 сая төгрөгийн хөрөнгийг ашиглаагүй агуулахад хадгалж байна. Үүнд 26.3 сая төгрөгийн нийт 8100 ширхэг аяга, таваг, халбага, сэрээг бэлтгэн авсан байна.



Зураг №6



Зураг №7



Зураг №8

- **2 дугаар сургууль:** 1,380.0 мянган төгрөгийн хөлдөөгч, 700.0 мянган төгрөгийн жигнүүр ашиглалтгүй хадгалагдаж байна.



Зураг №9



Зураг №10


- **5 дугаар сургууль:** Сургуулийн гал тогоог үдийн цай нийлдүүлэг аж ахуйн нэгжид түрээслүүлдэг бөгөөд шинээр бэлтгэсэн 35 нэр төрлийн 76.1 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг ашиглаагүй агуулахад хураасан байна.



Зураг №11



Зураг №12



Зураг №13

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

- Төслийн саналыг холбогдох аргачлалд заасан шалгуур үзүүлэлтээр судалж, эрэмбэлээгүй, хэрэгцээ шаардлага, ач холбогдлоор нь үнэлээгүй, үр ашгийг тооцоолгүйгээр холбогдох салбарын Сайдад хүргүүлсэн байна.
- Төсвийн тухай хууль батлагдсаны дараа магадлалаар баталгаажуулж байгаагаас батлагдсан төсөв хүрэлцэхгүй байх, төсөвт тусгагдаагүй нэмэлт ажил бий болох зэрэг эрсдэл үүссэн байна.
- 2020 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээнд хөрөнгө оруулалтын шинж чанартай бус төсөл батлагдаагүй байна.
- ТАХ хугацаандаа хэрэгжихгүй байгаа нь нэг гүйцэтгэгч олон ажилд зэрэг шалгарсан, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа боловсон хүчний хүрэлцээ, чадавхыг тооцоогүй, он дамжин санхүүжих ажлыг тухайн онд дуусгахаар гэрээ байгуулдаг, инженер геологийн судалгааны ажлыг чанаргүй гүйцэтгэснээс нэмэлт ажил хийгддэг, зураг төсөл ТЭЗҮ, инженер геологийн ажил хийгдээгүй байхад төсөв батлагдсан зэрэг нь голлон нөлөөлсөн байна.
- Тендерийн баримт бичгийг худалдан авах ажлын төрөл болон худалдан авах ажиллагааны хэлбэртэй холбоотойгоор Сангийн яамнаас баталсан тендерийн жишиг баримт бичиг, гэрээний маягт болон тендер шалгаруулалтад холбогдох бусад журам аргачлалын дагуу бэлтгэн боловсруулж, тендерийн баримт бичгийг цаасаар болон цахим хэлбэрээр бүрдүүлсэн байна.
- ТБОНӨХБАҮХАТ хуулийн 21.1-д “Захиалагч тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, худалдан авах ажиллагааны цахим систем болон хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ” гэж заасан байхад 10 хоногт нэг удаа, сард гурван удаа хэвлэгддэг аймгийн “Өнөөгийн Дорноговь” сонинд тендерийн урилгыг хэвлүүлсэн байна.
- Үнэлгээний хороо ТББ-ийг үнэлэхдээ үнийн харьцуулалт судалгаа хийгээгүйгээс ижил төрлийн барааг үнийн хувьд харилцан адилгүй нийлүүлсэн, зарим тоног төхөөрөмжийг зах зээлийн үнээс хэт өндрөөр нийлүүлсэн байна.
- Захиалагчийн болон зохиогчийн хяналтыг барилга угсралтын үе шат бүрд хэрэгжүүлсэн ч хяналтаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг дүгнэх, баримтжуулах үйл явц хангалтгүй байна.
- Зарим ТАХ-ний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэж олгоогүй, эрх бүхий албан тушаалтнууд гүйцэтгэлийг бодитоор гараагүй байхад баталгаажуулсан байна.
- Хөрөнгө оруулалтын үйл явцад дотоодын хяналт тавих чиг үүрэг хэрэгжихгүй байна.

- Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний ажил хийгдсэн бөгөөд тэдгээрийг зүгшрүүлэх, тохируулах хугацаанд чанарын баталгааны 5 хувийг авч үлдэж байгаа нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг бүрэн хангуулахад түлхэц болсон байна.
- Барилга, байгууламжийг данс бүртгэлд тусгах үнэ тодорхой бус, оны эцэст ашиглалтад хүлээн авах комиссын дүгнэлт гарснаас тухайн ондоо багтаж бүртгэлд тусгах шийдвэр гараагүй зэргээс шалтгаалан 2020 онд ашиглалтад орсон барилга, байгууламж, тоног төхөөрөмжийг данс бүртгэлд тусгаагүй байна.
- Хөрөнгө оруулалтыг төлөвлөхдөө ирээдүйд хүртэх үр өгөөж, хэрэгцээ шаардлага, цаашид гарах урсгал болон ашиглалтын зардлыг урьдчилж тооцоогүйгээс хөрөнгийн ашиглалт хангалтгүй байна.

Аудитаар нийт 6,938.7 сая төгрөгийн 13 зөрчил илрүүлж, зөрчил арилгах, давтан гаргахгүй байх, хөрөнгө данс бүртгэлд бүртгэх зэрэг нийт 2,151.9 сая төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага, гүйцэтгээгүй ажлын санхүүжилтийг төлүүлэх 4.7 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, холбогдох албан тушаалтнуудад 8 зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт, нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА О.БАТЖАРГАЛ ТАНАА:

1. Орон нутгийн хэрэгцээ шаардлагад үндэслэсэн, ТЭЗҮ, зураг төсөв нь батлагдсан, нийгэмд үзүүлэх ач холбогдлоороо нэн тэргүүний хөрөнгө оруулалтыг эрэмбэлэн, төсвийн Ерөнхийлөн захирагч болон Сангийн яаманд хүргүүлж байх.
2. Үнэлгээний хорооны гишүүдийг мэргэшүүлэх, үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд захиалагч байгууллагын төлөөлөл болон тухайн чиглэлээр мэргэшсэн боловсон хүчнийг түлхүү оролцуулах, оролцогчийн чадавхыг бодитой үнэлэх шалгуурыг ТББ-т тусгах, үнийн саналыг зах зээлийн үнэ ханштай харьцуулан судлах.
3. Хөрөнгө оруулалтын ажилд санхүүгийн хяналтыг хэрэгжүүлэх, дотоод хяналтын үр нөлөөтэй тогтолцоог бий болгох.

АЙМГИЙН ЗДТГ-ЫН ДАРГА Н.ХОНГОРЗУЛ ТАНАА:

1. Захиалагч, зохиогчийн хяналтын гэрээний зүйл заалтыг хангуулж, бодитой үнэлж, дүгнэсний дараа тохирох санхүүжилтийг олгож байх.
2. Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний үүргийг хангуулж, гэрээ зөрчсөн гүйцэтгэгчтэй хариуцлага тооцож байх.


ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА Ц.ОЮУНСАЙХАН ТАНАА:

1. Зохиогчийн хяналтын гэрээг үнэлж, дүгнэсний дараа санхүүжилт олгох эрхийг ЗДТГ уламжлах.
2. Захиалагчийн хяналтаар өгөгдсөн зөвлөмж, үүрэг даалгаврын биелэлтийг дүгнэх, баримтжуулах.

ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН АЛБАНЫ ДАРГА У.БАЯРБИЛЭГ ТАНАА:

1. ТБОНӨХБАҮХАТ хуулийн 21.1-д “Захиалагч тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, худалдан авах ажиллагааны цахим систем болон хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Т.ГАН-ӨЛЗИЙ

АУДИТЫГ ГҮЙЦЭТГЭСЭН БАГИЙН ГИШҮҮД :

Ахлах аудитор:

Аудитор:



Ч.Ариунаа

Т.Мөнхтогтох

ХЯНАСАН:

Аудитын менежер:

Дарга, тэргүүлэх аудитор:



У.Оюунтүлхүүр

Т.Ган-Өлзий

**АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХАМТРАН ОРОЛЦСОНД
ТАЛАРХАЛ ИЛЭРХИЙЛБЕ.**

Хавсралт №1

Орон нутгаас санал хүргүүлээгүй батлагдсан ТАХ-ний жагсаалт

№	Төсөл, арга хэмжээний нэр	Хэрэгжүүлэх хугацаа		Төсөвт өртөг	2020 онд санхүүжих
		Эхлэх	Дуусах		
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд					
1	Дорноговь аймгийн Сайншанд сумын 13 дугаар цэцэрлэгт тавилга, тоног төхөөрөмж нийлүүлэх	2020	2020	10.0	10.0
2	Цэцэрлэгийн дотор хаалга, заслын ажил /Дорноговь, Сайншанд сум, 6 дугаар цэцэрлэг/	2020	2020	90.6	90.6
3	Цэцэрлэгийн барилгын их засвар /Дорноговь, Сайншанд сум, 1 дүгээр цэцэрлэг/	2020	2020	165.0	165.0
4	Кино театрт тавилга, тоног төхөөрөмж худалдан авах /Дорноговь Сайншанд/	2020	2020	165.0	165.0
5	Сургуулийн барилгын гадна фасад, дээврийн засвар /Дорноговь, Сайншанд сум, 5 дугаар сургууль/	2020	2020	211.1	211.1
6	Сургуулийн барилгын их засвар /Дорноговь, Өргөн сум/	2020	2020	217.2	217.2
7	Сургуулийн гал тогооны тоног төхөөрөмж /Дорноговь, Сайншанд сум, 1, 2, 5 дугаар сургууль/	2020	2020	231.0	231.0
8	Сургуулийн барилгын их засвар /Дорноговь, Хатанбулаг сум/	2020	2020	234.2	234.2
9	“Монгол соёл-Монгол хүмүүн” төсөл хөтөлбөр /Дорноговь, Алтанширээ, Сайхандулаан, Өргөн, Даланжаргалан, Айраг, Дэлгэрэх, Иххэт, Мандах сум/	2020	2021	1,500.0	300.0
Нийт				2,824.1	1,624.1
Эрүүл мэндийн сайд					
10	Төмөр замын эмнэлгийн тоног төхөөрөмж /Дорноговь, Сайншанд сум, 4 дүгээр баг/	2020	2020	48.1	48.1
11	Төрөх эмнэлгийн тоног төхөөрөмж /Дорноговь, Сайншанд сум, 2 дугаар баг/	2020	2020	103.8	103.8
Нийт				151.9	151.9
Эрчим хүчний сайд					
12	Замын-Үүд дулааны станцын шугам сүлжээ /Дорноговь, Замын-Үүд сум/	2020	2020	335.0	335.0
13	Замын-Үүд боомтын шугам сүлжээ /Дорноговь, Замын-Үүд сум/	2020	2020	1,220.0	1,220.0
Нийт				1,555.0	1,555.0
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд					
14	Хүүхдийн зуслан байгуулах /Дорноговь/	2020	2021	1,600.0	50.0
Нийт				1,600.0	50.0
Нийт дүн				6,131.0	3,381.0

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:

№1



ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум, 3 дугаар баг,
Нутгийн удирдлагын ордон, Утас: 7052 2533,
Факс: (976) 7052 2530, И-мэйл: zdtg@dornogovi.gov.mn,
Вэбсайт: dornogovi.gov.mn

Долл. 04.28 № 01/576
танай Долл. 04.28 -ны № 1-6/376. -т

Санал хүргүүлэх тухай

“Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаж санал хүргүүлэв.

1.Хөрөнгө оруулалтын ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэхэд Ковид цар тахлын улмаас барилгын материал импортлох ажил удаашралтай байгаа, ажил гүйцэтгэх явцад магадлашгүй ажил хийгдсэн, Алтанширээ, Даланжаргалан, Хатанбулаг сумдад төвлөрсөн дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээ барих ажил гүйцэтгэх явцад трассын дагуу хөрсний ус ихээр нэвчиж ажил удаашруулсан зэрэг шалтгаан нөхцөл үүссэнтэй холбоотой ажил гүйцэтгэх хугацаа хойшилсон.

2.”Монгол соёл-Монгол хүмүн” төсөл арга хэмжээний ажил 2020 онд эхэлж гүйцэтгэгч компани бараа материал захиалах хөрөнгө мөнгө шаардлагатай байгаа тул санхүүжилтийг олгож өгөх хүсэлт ирүүлсэн, Ковид-19 цар тахлын улмаас импортоор авах бараа материалыг худалдан авах ажлыг гүйцэтгэгч тал өөрийн биеэр гадаад улсад зорчиж гүйцэтгэх боломжгүй болж цахим системээр захиалга хийсэн, Монгол улсын 2020 оны төсвийн тухай хуульд батлагдсан хөрөнгө оруулалтын санхүүжилтийг тухайн онд санхүүжүүлэх шаардлага үүссэнтэй холбоотой санхүүжилтийн баримтыг баталгаажуулан Сангийн яаманд хүргүүлсэн.

3.Сайншанд суманд баригдсан 50 ортой төрөх эмнэлэгийн санхүүжилт 2350,0 сая төгрөг батлагдсан. Аймаг орон нутгаас гүйцэтгэлийг баталгаажуулан хүргүүлэхээс өмнө Сангийн яамнаас шийдвэрлэж тус төсөлд 4074,1 сая төгрөгийн санхүүжилтийн эрхийг нээж олгосон.

4.Сайншанд сумын 2-р сургуулийн өргөтгөлийн барилгын ажлын захиалагчаар БШУЯ ажиллаж байгаа бөгөөд, гүйцэтгэлийн санхүүжилтийг шууд БШУЯ-аас шийдвэрлэн олгосон.

Тайлантай холбоотой хүргүүлж байгаа саналыг тайланд тусган ажиллана уу.



О.БАТЖАРГАЛ

44 5210671

№2



ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум, 3 дугаар баг,
Утас: (705) 2-39-98

Вэб сайт: dornogovi@gazar.gov.mn

2021.04.29 № 356
танай 2021.04.26 ны № 1-6/375 -т

**АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Т.ГАН-ӨЛЗИЙ ТАНАА**

Танай байгууллагаас ирүүлсэн “Улсын төсвийн
2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний
хэрэгжилт, үр дүн, үр ашиг” сэдэвт гүйцэтгэлийн
аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тайлангийн төсөлд манай газраас тусгах
саналгүй болно.

ДАРГА



Ц.ОЮУНСАЙХАН

443210738

№3



ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТДЭГ
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР
44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
Аймгийн ЗДТГ-ын байр 103 тоот,
Утас/факс: (705) 2-00-04
2021.04.28 № 100
танай 2021.04.26 -ны № 1-6/374 -т

**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
Т.ГАН-ӨЛЗИЙ ТАНАА**

Танай ирүүлсэн 2021 оны оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 1-6/374 тоот албан бичигтэй танилцлаа.

Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д заасны дагуу 2021 онд “Зууны мэдээ” өдөр тутмын сонинтой хамтран ажиллаж байна.

Гарсан дүгнэлт тайланд санал байхгүй болно.

ДАРГА  У.БАЯРБИЛЭГ


315924
4418270321

443102513

Г:ОНӨГ/ТООТ

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР:

Аймгийн Засаг даргаас ирүүлсэн саналд:

1. Алтанширээ, Даланжаргалан, Хатанбулаг сумдад хийгдсэн төвлөрсөн дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээ барих ажлын гэрээний хугацаа 2-4 сараар хэтэрсэн шалтгаан, үр дагаврыг тайлангийн Б.2.1 дэх хэсэгт тодорхой дурдсан. Харин дээрх зөрчилд гэрээний алданги тооцуулах бус, цаашид гэрээний хугацаа хэтрүүлсэн гүйцэтгэгчтэй алданги тооцдоггүй зөрчлийг таслан зогсоох, байгуулсан гэрээ хэлцлийн үр дүнг үнэлж, дүгнэснийг үндэслэж эцсийн санхүүжилтийг олгож байхаар албан шаардлага өгөхөөр шийдвэрлэсэн.
2. “Монгол соёл-Монгол хүмүүн” төслийн гэрээг 4 багц болгон зарласан бөгөөд УТ-НТШ-10/2020-01, 02, 03, 04 тоот гэрээний 5 дахь заалтад “Захиалагч тал нь тоног төхөөрөмж болон бусад хийгдэх ажлыг бүрэн хүлээн авч, актаар баталгаажуулан Сангийн яаманд уламжилж, санхүүжилтийг олгоно” гэж заасан. Гэтэл захиалагч гэрээний зүйл, заалтыг зөрчиж гүйцэтгэлийг баталгаажуулж Сангийн яаманд хүргүүлсэн тул тайланд засвар оруулах боломжгүй байна.
3. Сайншанд суманд баригдсан 50 ортой төрөх эмнэлгийн санхүүжүүлэх эрхийг Сангийн яам нээсэн ч санхүүжилтийг олгоход шаардлагатай үндсэн баримт болох гүйцэтгэлийг аудитын явцад ирүүлээгүй тул тайланд өөрчлөлт оруулах боломжгүй байна.
4. Бид тус аудитыг ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар гүйцэтгэж байгаа тул Сайншанд сумын 2-р сургуулийн өргөтгөлийн барилгын ажилтай холбоотой зөрчлийг тайланд тусгасан болно.

АУДИТЫН ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ:



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2021 оны 05 сарын 18 өдөр

Дугаар А/13


Дорноговь аймаг, Сайншанд сум

Гүйцэтгэлийн аудитын тайлан баталгаажуулах тухай

Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 9 дүгээр зүйлийн 9.1, 20 дугаар зүйлийн 20.1, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2018 оны А/207 дугаар “Эрх, үүрэг шилжүүлэх тухай” тушаалын 5 дугаар хавсралтын 1.3, 2.4, 2020 оны А/106 дугаар “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам” тушаалын 18.9, 2021 оны А/28 дугаар “Төрийн аудитын байгууллагын 2021 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө” тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитаар өгсөн акт, албан шаардлагуудыг хавсралтаар баталсугай.
3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, үр дүнг 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлэхийг аймгийн Засаг дарга, аймгийн Засаг даргын Тамгын газар, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Орон нутгийн өмчийн газрын дарга нарт тус тус зөвлөсүгэй.
4. Аудитын тайланг Үндэсний аудитын газар, аймгийн Засаг дарга, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Орон нутгийн өмчийн газрын дарга нарт хүргүүлсүгэй.
5. Акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (У.Оюунтүлхүүр)-т даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Т.ГАН-ӨЛЗИЙ

010010147

-2-

Дорноговь аймаг дахь Төрийн аудитын
газрын дарга, тэргүүлэх аудиторов
2021 оны 06 дүгээр сарын 18 -ны өдрийн
А/13 дугаар тушаалын хавсралт

Аудитаар өгсөн акт, албан шаардлагын жагсаалт

4417144353
1000056 9025707

Д/д	Зөрчил	Дугаар	Зөрчлийн утга	Мөнгөн дүн /мянган төгрөг/	Хариуцах албан тушаалтны нэр
1	Төлбөрийн акт	17/A1060293 ДГА-2021/06-9- ШТА-ГА	Төлбөр барагдуулах тухай	4,781.0	Н.Хонгорзул А.Амгаланзаяа
2	Албан шаардлага	67/A1060293 ДГА-2021/06-9- ШТА-ГА	Зөрчил арилгах тухай	-	О.Батжаргал Н.Хонгорзул
3	Албан шаардлага	68/A1060293 ДГА-2021/06-9- ШТА-ГА	Ажил дуусгуулах тухай	10,212.0	Н.Хонгорзул А.Амгаланзаяа
4	Албан шаардлага	69/A1060293 ДГА-2021/06-9- ШТА-ГА	Илүү олгосон санхүүжилтийг суутгах тухай	5,576.8	Н.Хонгорзул А.Амгаланзаяа
5	Албан шаардлага	70/A1060293 ДГА-2021/06-9- ШТА-ГА	Хөрөнгө данс бүртгэлд тусгуулах тухай	2,136,106.2	Н.Хонгорзул А.Амгаланзаяа
Нийт дүн				2,156,676.0	

000